

ШРИФТ БУЮУ ҮСГИЙН ФОНТНЫ ТУХАЙ

С.Дэлгэрмаа*

* "Их Монгол" дээд сургуулийн Сэтгүүл зүйн тэнхмийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

Түлхүүр үг: шрифт, үсгийн фонт, үсгийн бүл, сериф буюу хэрчээс, эрс тэсийн ялгарал.

Сонин хэвлэлийн эхийг бэлтгэх явцад мэдээллийг компьютерт оруулах ёстой. Үүний тулд шрифт буюу үсгийн фонтыг хэрэглэдэг. Тэгвэл энэ шрифт гэдэг нь чухам юу юм бэ?

Шрифт гэдэг үг нь *script* буюу захиа гэсэн герман үгээс гаралтай бөгөөд авиа чимээг илэрхийлдэг дүрс тэмдэгт юм. Цогц утгаараа уншигчдад мэдээллийг дамжуулах үндсэн үүрэгтэй сонин дизайны тулгуур ойлголтуудын нэг билээ. Шрифт нь бие даасан дүрслэх урлаг бөгөөд эрдэмтэд үе үеийн турш түүнийг судлан шинжилж, янз бүрээр тодорхойлж иржээ. Нэгэн судлаачийн тодорхойлсноор "Шрифт гэгч утга мэдээллийг илэрхийлэгч, дамжуулагч бус оюунд нэвчигч, сэтгэлд оршигч билэгдлийн үр ажээ"¹.

Сонин хэвлэлийн дизайны гол асуудлын нэг нь шрифтыг оновчтой зөв

сонгох асуудал бөгөөд уншигчдад хялбар уншигдахгүй л бол сайн шрифтэд тооцогдохгүй ч зарим тохиолдолд нарийн, ур хийцтэй, чамин шрифт хэрэглэхийг үгүйсгэхгүй.

Шрифтийн үүсэл, хөгжил

Анхны дүрс үсгээс эхлээд орчин үеийн компьютерийн технологиор гаргаж авч байгаа үсгийн фонт хүртэлх асар урт хугацаанд шрифт боловсронгуй болж, хөгжиж ирсэн түүхтэй бөгөөд бие даасан судлал болжээ.

Манай эриний өмнөх VIII-VI мянганы үед эртний Финикид анхны цагаан толгой бий болсон гэж үздэг². Өөр хэсэг судлаачийн нотолдгоор, бичиг үсэг анх одоогийн Иракийн нутаг дэвсгэр дээр оршиж байсан Шумерын хаант улсад бий болжээ. Финикчүүдийн бичиг үсгийн дурсгал одоог хүртэл хадгалагдан үлдсэн байдаг. Тэдний цагаан толгойг эртний герегчүүд хуулбарлан авч, анхны шрифтийг бүтээсэн нь агаар ихтэй, эрс тэсийн ялгарал багатай, дүрслэг

хэрчээсгүй, энгийн байжээ. Герегчүүдээс бичиг үсгийг нь ромчууд өвлөн авч, латин хэлбэрийн шрифтийг бий болгосон нь эрс тэсийн ялгаралтай, хэрчээстэй, өр нь гоёмсог хэлбэртэй болж ирсэн байна. Дундад зууны үед готик үсэг гарсан нь ном хэвлэлийг илүү иргэнлэг болгоод зогсохгүй, уншихад хялбар, энгийн үсэг болжээ. Хэвлэлийн материалын чанар сайжирч, тэр чинээгээрээ ном хэвлэлийн үнэлэмж ч дээшилсэн байна. XIV зуунд хөрөнгөтний нийгэм хөгжин цэцэглэж, хүнлэг иргэнлиг үзэл санаа ноёрхож, тэр нь иргэний шрифт болох каролинг үсгийг үүсгэсэн аж.

1455 онд Германы Майнц хотын иргэн, алт мөнгөний дархан Йохан Гутенберг нэрээр түүхэнд үлдсэн Йохан Генсфлайш-Ладен (1397-1468) зөөврийн хөдөлгөөнт үсэг сэдэж, хэвлэлийн анхны суурь машин зохион бүтээж³, хэсэг нөхдийн хамт анхны шрифт болох blackletter буюу хар үсэг хэмээн нэрлэгддэг шрифтийг гаргаж хэрэглэсэн юм. Энэ нь хэлбэр муутай, бүдүүлэгдүү, зузаан, хар бараан шрифт байсан болохоор түүнийг шрифт судлаачид түүхэнд "хар үсэг" гэж нэрлэсэн байна.

Дараахан нь Италид Петрарка илүү гэгээлэг, цайвар, гоёмсог хийцтэй шрифт гаргаж ирсэн нь одоогийн бидний хэрэглэдэг Roman шрифтийн анхдагч нь болсон юм.

1501 онд Альд Мануций бага зэргийн налуу, хазайлттай шрифтийг зохиожээ. Энэ шрифт нь тухайн үедээ

маш шинэлэгт тооцогдож байсан бөгөөд одоогийн бидний хэрэглэдэг *Italic* буюу налуу хэлбэр билээ. Ийнхүү шрифтийн төрөл, хэлбэрүүд үүссээр байсан бөгөөд 1692-1766 онд амьдарч байсан Английн шрифт судлаач, зохиогч Уильям Кезлон улсынхаа хууль болон тусгаар тогтнолын тунхаглалыг өөрийн зохиосон *Caslon*

«

Шрифт гэдэг үг нь schrift буюу захиа гэсэн герман үгээс гаралтай бөгөөд авиа чимээг илэрхийлдэг дүрс тэмдэгт юм. Цогц утгаараа уншигчдад мэдээллийг дамжуулах үндсэн үүрэгтэй сошины дизайны тулгуур ойлголтуудын нэг шрифтыг оновчтой зөв сонгох бөгөөд уншигчдад хялбар уншигдахгүй л бол сайн шрифтэд тооцогдохгүй ч зарим тохиолдолд чамин шрифт хэрэглэхийг үгүйсгэхгүй.


»

шрифтээр бичиж үлдээсэн байна.

1950 онд Английн шрифт зохиогч Жон Баскервилл нэгэн шрифт зохион, Baskerville хэмээн өөрийнхөө нэрээр нэрлэсэн нь одоо ч дэлхийн хэвлэлийн зах зээл дээр өргөн хэрэглэгдсээр байна. XIX зуунд шрифтийн урлаг сонгодог утгаараа хөгжиж, алдарт Ф.Дидо, Ж.Бодони нар өөрийн үсгүүдийг сэдэж, чухам л эрс тэс, хэрчээсийг илүү хүчтэй ашиглах болсноор египет, гротеск үсгүүд зохиогджээ. Ингээд шрифтүүд ар араасаа цувран гарч эхэлсэн байна.

Шрифтийн ангилал

XX зуун гарахад хэвлэлд зар сурталчилгаа түлхүү хөгжсөнтэй холбоотойгоор илүү дутуу хэрчээс, зураасгүй сансериф шрифтийг бий болгожээ. Монголын сонин хэвлэл төдийгүй, албан бичигт хэрэглэгддэг Arial Mon шрифт нь сансериф үсэг бөгөөд мэдээллийн багтаамж сайтай, бичгийг илүү тод харагдуулдаг онцлогтой юм. Кирилл үсгийг ах дүү Кирилл, Мефодий нар шашны ном сургаал дэлгэрүүлэх зорилгоор зохиож, өмнөд Славян, Оросод түгээн дэлгэрүүлжээ⁴. Мөн 1900 онд Century (Сэнчери), 1902 онд Cheltenham (Чельтэнхэм), 1915 онд Baskerville roman (Баскервилл роман), 1918 онд Garamond (Гарамонд), 1950-аад онд Helvetica (Алдарт Универс Хелвитака), Optima, Palatino шрифт гарсан байна.

 нөөгийн дэлхийн хэвлэлийн зах зээл дээр цаг мөч тутам шинэ шрифтүүд шилээ даран гарч ирсээр л байна. Шрифтийн хэв загвар, дизайныг зохион худалддаг олон газруудаас хамгийн том нь Нью-Йорк хот дахь Олон улсын шрифтийн корпораци билээ.

Ер нь хэвлэлийн зах зээл дээр эрэлт ихтэй, сайн шрифт гарч ирэхэд түүнтэй төсөөтэй, дуурайсан хэлбэрүүд нь ар араасаа цувран гардаг. Иймд төсөөтэй шрифтүүдийг Таймс Романы бүлийнхэн гэх мэтчилэн анхдагчаар нь овоглодог байна. Бүлийн гишүүд ерөнхийдөө адилхан, зөвхөн өргөн, урт, хэлбэрээрээ ялгагддаг.

ХIХ зууны үед Францын шрифт судлаач Титидо шрифтийг эрс тэсийн ялгарал, дүрслэг буюу хэрчээсээр (сериф) нь дөрвөн үндсэн хэсэгт ангилжээ.

1. Латин шрифт — эрс тэстэй, хэрчээстэй.

2. Гротеск шрифт — эрс тэсгүй, хэрчээсгүй. Энэ шрифтийг анх Германы сэтгүүл зүйд хэрэглэсэн ба рекламны гарчиг бичдэг. Энэ шрифтийг шрифт судлаачид албархаг төрхтэй, уламжлалт шрифт гэдэг.

3. Египет шрифт — эрс тэсгүй, хэрчээстэй. Египетийн соёлыг бишрэн гайхаж байх үед Англид гарсан шрифт юм. Агаар их иддэг, муу шрифтэд тооцогддог. Манай зарим хэвлэл энэ хоцрогдсон шрифтийг одоо хэр нь хэрэглэж байна.

4. Ром — эрс тэстэй, хэрчээсгүй шрифт. Латин болон гротеск шрифтийн давуу, сайн талуудыг өөртөө агуулсан шрифт.

Харин хэвлэлийн дизайнер Моен нь шрифтийн ангилалыг доорх байдлаар хийсэн байна.

1. Романы төрлийн шрифтүүд — латин.

2. Серифгүй шрифтүүд — гротеск.

3. Серифтэй шрифтүүд — латин болон египет.

4. Хээ угалз чимэглэлтэй шрифтүүд — энэ шрифтэд Соса хэлбэрийн шрифтүүд багтдаг.

Ингээд эрс тэсийн ялгарал, дүрслэг буюу хэрчээс гэдэг нь чухам юу болох талаар тайлбарлая.

А үсэгний хоёр босоо зураас нь голынхоо зураасаас эрс өргөн байна. Энэ нь эрс тэсийн ялгарал юм

А үсгэн дээр харагдаж байгаа дээд оройн болон хоёр хөлний тулгуур болж буй хөндлөн богино зураас нь дүрслэг буюу хэрчээс юм.



Компьютерийн технологид тулгуурласан үсгийн фонт буюу шрифтийн тухай

Компьютерт үсгийн фонтыг вектор график дээр үндэслэж зохиодог. Фонт бүр нэг бүл үсгийн гишүүн болдог. Энэ нь дотроо normal-энгийн, bold-тод зузаан, italic-налуу, bolditalic-тод бөгөөд налуу гэсэн үндсэн дөрвөн төрлийн хэлбэрийг тус тусдаа агуулсан файлуудаас бүрддэг. Хэрэв аль нэг нь дутуу бол фонтны тухайн хэлбэрийг өнгө салгагч болон принтер илэрхийлж чадахгүй.

Компьютерт үсгийн фонтуудыг ерөнхийд серифтэй (Serif), серифгүй (San Serif) гэсэн хоёр төрөлд хувааж үздэг. Сериф гэдэг нь бидний дээр өгүүлсэн дүрслэг буюу хэрчээс юм.

Serif буюу серифтэй үсэгт Antiqua (Times) төрлийн үсгүүд хамаарна. Сериф бүлийн үсгүүд нь ихэвчлэн regular,

bold гэсэн хоёр төрлийн зузаантай ба roman, italic гэсэн хоёр янзын хэлбэртэй.

San Serif гэдэг нь серифгүй гэсэн утгатай бөгөөд энэ төрлийн үсгүүдийг Helvetica төрлийн үсгүүд гэж нэрлэдэг. Энэ төрөлд хамаарагдах үсгийн бүлүүд нь light (нарийн)-аас эхлээд extrabold- (маш бүдүүн) хүртэл нэлээд олон төрлийн зузаантай, regular (шулуун), oblique (пагдгар), condensed (шахсан), italic (налуу) зэрэг хэлбэртэй байдаг.

Мөн дээрх хоёр төрөлд хамаарахгүй үсгүүд байдаг. Эдгээрт гар бичмэл хэлбэртэй үсгүүд буюу Cursive төрөл, ердийн бус этгээддүү хэлбэрээр хийгдсэн үсгүүд буюу Novelty төрлийн үсгүүд орно.

Үсгийн өндрийг бид *point* (пойнт) хэмжээсээр хэмждэг. 72 пойнт нь 1 инч буюу 2,54 см болдог.

Энэ хэмжих нэгж XVIII зуунд үүсчээ. Тэр үед мод болон тугалгаар бар үсэг хийж ашиглаж байсан бөгөөд үсэг нь 9, 10, 12, 14, 18, 24, 30, 36, 48, 60, 72 пойнт гэсэн тогтмол стандарт хэмжээтэй байсан ба одоо ч хэрэглэж байна. Харин зарим хэвлэлийн дизайны програмууд үсэг, мөр хоорондын зайг мм-ээр тодорхойлдог болсон.

Kerning-кернинг гэдэг нь зарим үсгүүдийн хоорондын зайг багасгадаг. Жишээлбэл: Г, Р, Ү, А, У, Т зэрэг гийгүүлэгчийн дараа жижиг үсэг орвол тэдгээрийн хоорондын зайг багасгахгүй бол салангид мэт харагддаг. Бидний өргөн хэрэглэдэг монгол (true type) фонтны хувьд оросын кирилл үсгийг авч

ашиглахдаа кернинг таблицийг нь хамт аваагүй тул кернинг хийж болдоггүй сул талтай. Кернинг хийснээр нүдэнд нэгдмэл харагддаг бөгөөд уншигчдын харачуйг бага чилээдэг байна.

Tracking-тракинг гэдэг нь үсэг хоорондын зайг өөрчилдөг. Үсгийн өргөнийг өөрчилж болно. Өөрчлөлтийг ялимгүй багаар хийх хэрэгтэй. Хэтрүүлбэл үсгийн вектор бүтэц алдагдана.

Сэтгэл зүйд үзүүлэх шрифтийн нөлөө

Манай хэвлэл мэдээлэл, реклам сурталчилгаа, хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт сэтгэл зүйд үзүүлэх шрифтийн нөлөөний талаар хийсэн судалгаа байхгүй, энэ талын мэдлэг зарим нэгэнд нь тун хомс байна⁵. Ялангуяа сонинуудын хувьд телевизийн программын хөтөлбөрийг хэтэрхий жижигхэн, шахмал шрифтээр бичсэн нь яаж ч хичээгээд уншигддаггүй, заруудыг тас хар фон дээр бичсэн нь уншигчдын сэтгэл зүйд тухайн сонголт ямар сэтгэгдэл төрүүлэхийг урьдчилан хэлэхийн аргагүй.

Шрифтийн сонголт хүний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдөг тухай сэтгэл судлаач, доктор Эрик Сигман (Aric Sigman) судалгаа хийж “Шрифтийн сэтгэл зүй” гэсэн ном гаргажээ. Энэхүү судалгаагаар компьютераасаа ямар шрифт сонгох зуршилтай нь тэр хүний мөн чанарыг илэрхийлэхийн зэрэгцээ санамсаргүй сонгосон шрифт уншигчдад ямар сэтгэгдэл

төрүүлэхийг урьдчилан хэлж болох ажээ⁶.

Зарим шрифтүүд бараг бүх бичлэгийн төрөл зүйл, нийтлэл материалд тохирч байдаг бол зарим нь тэр бүр тохирдоггүй. Шрифт бүр өөр өөрийн онцлог шинж чанартай. Гол гол шрифтүүдийн онцлог шинжүүдийг дурдвал:

- Baskerville – сайхан, эелдэг төрхтэй,
- Bodoni – албархаг, эрхэмсэг, язгууртны төрхтэй,
- Caslon – сүр жавхаатай,
- Century – гоёмсог, тодорхой,
- Cheltenham – болхи, найдвартай, үнэнч,
- Franklin Gothic – шулуун, эрчимтэй, шуурхай,
- Future – хатуу, ширүүн, ашиг тустай, үр нөлөөтэй,
- Garamond – уян налархай хэврэг,
- Standard – эмх цэгцтэй, шинэлэг,
- Times Roman – уламжлалт, үр нөлөөтэй, бат бөх шинж чанарыг илэрхийлдэг.

Судалгаагаар тэгш шулуун, хурц өнцөгтэй шрифт нь эрчүүдийн сэтгэлийг татдаг бол хүүхнүүдэд титэм зурлага бүхий ганган гоёмсог шрифт таалагддаг аж. Courier төрлийн шрифт нь бичгийн машины үсэгтэй төстэй учир хуучинсаг үзэлтэй хүмүүс ихэвчлэн хэрэглэдэг байна. Times Roman болон Palatino (серифтэй) төрлийн шрифт нь шинэ, хуучин хоёрын холбоос болж байдаг бөгөөд хэлбэр сайтай, энгийн учир итгэл үнэмшил төрүүлэх чанартай тул

амгөөлөгчид, бизнесийн нэр хүндтэй байгууллагынхан хэрэглэх дуртай. Серифгүй шрифт болох Arial, Modern, Univers зэрэг нь сэтгэлийн хийрхэл багатай, төлөв төвшин, эрүүл сэтгэлгээг илэрхийлдэг бол бичмэл төрлийн шрифтууд нь хэн нэгэнтэй дотно, нөхөрсөг харьцаа тогтоохыг илтгэдэг гэнэ. Иймд бичмэл фонтуудыг банкныхан болон томоохон корпорацийн ажилтнууд их хэрэглэдэг нь ард олонтойгоо ойр дотно гэдгээ харуулах оролдлого юм байна.

Монголын хэвлэлийн шрифтийн хэрэглээ

1990-ээд оны эхэн үеийг хүртэл Монголын сонинуудын хэрэглээ үндсэндээ цөөн тооны хэдэн шрифтийн дотор эргэлддэг байсан бол одоо харьцангуй шрифтийн сонголт өргөнтэй болсон юм. Манай өдөр тутмын сонинууд ихэвчлэн латин болон гротеск хэлбэрийн шрифтууд хэрэглэдэг. Шрифтийн сонголт олон болохын хэрээр дизайнер хүн тухайн материал нийтлэлд зохицуулан, шрифтээ сонгох нь амаргүй байдаг.

Дэлхийн жишгээр шрифтийг хоёр зориулалтаар хэрэглэдэг.

1. Эх бичвэрт хэрэглэгддэг шрифтууд,
2. Сонины толгой буюу гарчигт хэрэглэгддэг шрифтууд.

Гэтэл манай сонинууд эх бичвэрийн шрифт, гарчиг болон толгойн шрифтийг ялгаж салгаж хэрэглэхгүй байгаа нь түгээмэл ажиглагддаг. Латин хэлбэрийн

шрифтүүдийг сонины толгойд ашиглах нь тохиромжгүй гэж хэвлэлийн дизайнерууд үздэг. Харин манайд энэ төрлийн шрифтийг сонины толгойд нэлээд ашигладаг. Тухайлбал, "Монголын мэдээ", "Хүмүүс" зэрэг сонин эх бичвэрийн шрифтийг толгойн шрифтэд ашигладаг.

Албан ёсны буюу консерватив төрлийн мэдээ, мэдээллийн сонины хувьд текст нь сериф төрлийн, гарчиг нь сериф, сан сериф төрлүүдийн аль нь ч байж болох ба цөөн тооны үсгүүдээр бичигдсэн байдаг. Толгой үсгийг нэг их хэрэглэдэггүй.

Харин шар сонин буюу сенсаци хөөдөг сонины текст нь сериф болон сан серифийн аль нэг, гарчиг нь бүх төрлийн үсгээр хийгдсэн, ерөнхий дизайн нэлээд өвөрмөц хийгдсэн байдаг. Толгой үсэг, дэвсгэр өнгө, төрөл бүрийн эффектийг өргөн хэрэглэдэг.

Европын эрдэмтэд судалгаагаараа сериф төрлийн 8-9 пойнтын үсгээр, мөр хоорондын зай нь 8.5-9.5 байхаар бичигдсэн үргэлжилсэн текстийг уншихад хүний нүдэнд тохиромжтой болохыг тогтоосон байна. Мөн хамгийн их сонин уншигч хүмүүс бол тэтгэврийн насны хөгшчүүл байдаг бөгөөд ойрын хараа муу байдгаас жижиг үсгээр бичсэн зүйлсийг уншихаас төвөгшөөдөг ажээ.

Сүүлийн үед Монголын хэвлэлд шинэ сонин шийдэлтэй, өвөрмөц шрифтууд олноор гарч, манай сонинууд тэдгээрийг хэрэглэх болсон билээ. Гэхдээ сэтгэлийн хөдөлгөөнөөр гоё шрифт сон-

гоход бэлтгэсэн хэвлэлийн эхийг нь компьютерт таниулахад ихээхэн хүнд-рэлтэй, засвар хийх боломжгүй, ялангуяа ө, ү хоёр үсгийг танихгүй байх нь олон-таа тохиолддог. Иймээс манайд хамгийн тулгамдсан асуудлын нэг нь яах аргагүй үсгийн фонтны стандарт юм. Программ-хангамж үйлдвэрлэгчид энэ асуудлыг шийдвэрлэхээр оролдож байгаа ч одоогоор нэг мөр болж чадаагүй байна.

Ишлэл:

¹ Болд – Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ., 42 дахь тал.

² Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ., 6 дахь тал.

³ Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ., 13 дахь тал.

⁴ Болд – Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ., 52 дахь тал.

⁵ Даваасүрэн Л. 2003-2004. Хэвлэ-лийн эх бэлтгэл ба дизайн. Прага-Улаанбаатар., 25 дахь тал.

⁶ Мөн тэнд, 26 дахь тал.

Ашигласан ном:

1. Андерсен Х. У., Мэллит М. Ф. 1998. Нийтлэл нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? УБ.

2. Баяртогтох М. 2004. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. УБ.

3. Болд – Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ.

4. Дамбажав И., Зундуй Л. 1989. Сонин гаргах урлаг. УБ.

5. Даваасүрэн Л. 2003-2004. Хэвлэ-лийн эх бэлтгэл ба дизайн. Прага-Улаанбаатар.

6. Зулъякафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

7. Зулъякафиль М., Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ.

8. Яцюк О. 2003. Компьютерные техно-логии в дизайне. Санкт-Петербург.

9. Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ.

Abstract

Researcher introduced about relationship origin and evolution of shrift between humanity's civilization, discovery and technology development by this article she showed many interesting research about how shrift to psychological of people, how shrifts are created in computer technology, scholars and researchers are how they made classifications of shrift. Furthermore she treed to talk about the facing problems and how Mongolian press use shrifts.